



2013 оны 4 сарын 2
(13-р хэвлэл)

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ Э-СОНИН

Мэдээний тойм:

- “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-аар хэлэлцэнэ
- Брокерууд өдөр тутмын арилжаанд алсаас оролцох тухай
- Үнэт цаасны арилжааны мэдээ
- Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй ХК-иудын үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орлоо
- Тендер санал зарласан ХК-иуд
- “Өнөөдрийн Монгол - Бодит байдалд хүрэх боломж” бага хурал
- Үнэт цаасны зах зээлийн мэдлэг олгох сургалт эхэлнэ

“Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын хаврын ээлжит чуулганаар хэлэлцэнэ

УИХ-ын хаврын ээлжит чуулган хуулийн хугацаагаараа энэ оны 4 дүгээр сарын 5-нд эхлэх бөгөөд УИХ-ын даргын 2013 оны 61 дүгээр захирамжаар УИХ-ын 2013 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоон гаргасан байна.

Хаврын чуулганаар хэлэлцэх асуудлын дарааллын 4 дүгээрт “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцүүлэхээр оруулсан байна.

“Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөлд үнэт цаасны давхар бүртгэлийн зохицуулалт, санхүүгийн хэрэгсэл, опцион, фьючерсийн гэрээ, хөрвөх үнэт цаас, үүсмэл санхүүгийн хэрэгсэл, болон хадгаламжийн бичиг, кастодианы үйл ажиллагааны гэх мэт зах зээлд нэн шаардлагатай зохицуулалтууд агуулагдсан юм.

Түүнчлэн, УИХ-ын хаврын чуулганаар “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай” хуульд өөрчлөлт оруулах тухай

хуулийн төсөл зэрэг чухал асуудлуудыг хэлэлцэхээр баталжээ.


Брокерууд өдөр тутмын арилжаанд өөрийн оффисоос оролцох боломжтой боллоо

Монголын хөрөнгийн бирж, Лондонгийн хөрөнгийн бирж групп болон Төрийн өмчийн хороо хамтран дотоодын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх зорилго бүхий “Ажлын мастер гэрээ”-г үзэглэн стратеги болон менежментийн түвшинд хамтран ажиллаж эхэлсэн цагаас хойш хоёр жилийн хугацаанд олон зорилтот ажлуудыг цаг хугацаанд нь хэрэгжүүлэн гүйцэтгэж олон нийтэд мэдээлэн хүргэж байсан билээ.

Гэрээнд тусгагдсан олон ажлуудын нэг болох Миллениум Ай Ти цогц системийг 2012 оны 7 дугаар сарын 2-ны өдөр Төлбөр тооцооны Т+3 аргачлалын хамтаар зах зээлд нэвтрүүлсэн бол өнөөдөр тус системийн давуу талуудын нэг болох зайнаас арилжаанд оролцох технологийн шийдэл, дэд бүтцийг бэлэн болгож брокерууд тус тусын оффисоос өдөр тутмын арилжаанд оролцох шинэ боломж нээгдээд байна.

Цаашилбал, энэхүү дэд бүтцийг ашиглан брокерууд өөрсдийн дотоод үйл ажиллагааны систем / Back office / болон харилцагчдад хандсан цахим аппликэйшн / Front office / зэргийг шинэчлэн боловсронгуй болгосноор харилцагчийн захиалгыг онлайн хэлбэрээр хүлээн авч арилжаанд оролцох боломж бүрдэх юм.

TOP-20 индексийн үзүүлэлт



2013 оны 3 дүгээр сарын 18-наас 29-ний хооронд нийт 10 удаагийн арилжаа явагдаж, 56 компанийн 1.3 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 2.6 сая ширхэг хувьцаа арилжсан байна.

Тус хугацаанд хамгийн идэвхтэй арилжигдсан компани нь “Монголиа девелопмент ресорсес” ХК /605.9 сая.төг/, “АПУ” ХК /174.2 сая.төг/ “Хай би ойл” ХК /155.6 сая.төг/ байсан байна.

Үнэт цаасны арилжааны мэдээ

Хувьцааны арилжаа: 3 дугаар сарын 18-ноос 29-ны хооронд:

Арилжаа явагдсан өдөр	10
Арилжигдсан ширхэг	2.6 сая
Арилжигдсан дүн	1.3 тэрбум.төг
Арилжигдсан компанийн тоо	56
Нийт хийгдсэн хэлцлийн тоо	567
Өдрийн дундаж	69.2 сая.төг

Хамгийн их өсөлттэй:	Уран барилга /UBA / +37,36%
	Булган гурил тэжээл /GTJ / +32,50%
	Хүнс-Архангай /HAN / +32,25%
бууралттай:	Монноос /MNS / -14,81%
	Баян-Алдар /VIK / -14,10%
	Шивээ овоо /SHV / -12,34%

Зах зээлийн үнэлгээ:	1,564.4 тэрбум.төг
	1.1 тэрбум ам.доллар

TOP-20 индексийн өөрчлөлт: 15,542.24 / -3.5%



“Ай трейд” ХХК-ийн хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгожээ

Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 136 дугаар тогтоолоор “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гишүүн брокер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхэлдэг “Ай трейд” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй ХК-иудын үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орлоо

д/д	МХБ-ийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орохын өмнөх ХК-ийн нэр	Холбогдох тогтоол, шийдвэрийн дугаар	Оноосон нэрийн өөрчлөлт
1	“Шад трейд” ХК (MSE:SDT)	СЗХ-ны 2012-12-26, тогтоол №385 МХБ-ийн 2013-03-29, тушаал №38	“Хот девелопмент” ХК (MSE:SDT)
2	“Цагдуултай” ХК (MSE:HAM)	СЗХ-ны 2013-02-06, тогтоол №43 МХБ-ийн 2013-04-03, тушаал №41	“Монголын хөгжил үндэсний нэгдэл” ХК (MSE:HAM)

Тендер санал зарласан ХК-иуд

д/д	ХК-ийн нэр	СЗХ-ны Тогтоолын дугаар	Нэгдмэл сонирхолтой этгээдүүд	Нэгдмэл сонирхолтой этгээдэд төвлөрсөн хувьцааны хэмжээ	Зах зээлээс татан төвлөрүүлэх хэмжээ	Зах зээлээс худалдаж авах доод үнэ	Тогтоолын хүчинтэй хугацаа
1	“Хэрэглээ импекс” ХК (MSE:HIE)	2013-03-13 №78	Л.Чулуунчимэг, Х.Будрагчаа	70.9 хувь буюу 37578 ширхэг	29.10 хувь буюу 15422 ширхэг	3,687 ₮	2013-03-13-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоног
2	“Тэгш” ХК (MSE:HAL)	2013-03-27 №135	Д.Ганбат, Г.Мөнх-Эрдэнэ, “Элеганттаун” ХХК	98.07 хувь буюу 153835 ширхэг	1.93 хувь буюу 3022 ширхэг	2,987 ₮	2013-3-27-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоног
3	“Увс хүнс” ХК (MSE:HUN)	2013-03-27 №134	О.Амартүвшин, Н.Цэрэнбат, Д.Гомбо, Л.Мөнхнаран	99.84 хувь буюу 112532 ширхэг	0.16 хувь буюу 184 ширхэг	150 ₮	2013-3-27-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоног

“Өнөөдрийн Монгол - Бодит байдалд хүрэх боломж” бага хурал

РwС компанийн зохион байгуулсан “Өнөөдрийн Монгол - Бодит байдалд хүрэх боломж” бага хурал 2013 оны 3-р сарын 20-ны өдөр ХонгКонгд амжилттай болж өндөрлөлөө.

Тус бага хуралд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, Монголбанк, Хаан банк болон Худалдаа хөгжлийн банкны төлөөлөгчид дотоодын санхүүгийн зах зээлийг төлөөлөн оролцсон бол JP.Morgan, Citi, BNY Melon, BNP Paribas, HSBC, HK Merchantile Exchange, GBST, CLSA, Fundsupermart, Adamas Asset Management болон Quam Asset Management зэрэг олон улсад нэртэй банк, санхүүгийн байгууллагууд болон бизнесийн байгууллагууд байлцан 80 орчим зочид, төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй өргөн дэлгэр болжээ.

Уулзалтын үеэр эх орны төлөөлөгчид Монгол Улсын санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал болон ирээдүйн

хөгжлийн стратеги, зорилтот төлөвлөгөөнүүдийг олон улсын түншүүдэд танилцуулсан бол нөгөө талаас Монгол орны эдийн засаг, хөрөнгө оруулалтын ирээдүйн боломж бололцоог хэрхэн харж буйгаа илэрхийлэхийн зэрэгцээ олон улсын туршлагаас хуваалцан, хамтран ажиллах хүсэлтээ илэрхийлж тулгамдаж буй зарим асуудлууд дээр ярилцаж хэлэлцсэн байна. Түүнчлэн компаниуд өөр хоорондоо уулзалт зохион байгуулж бизнесийн өргөн холбоос үүсгэж байсан нь арга хэмжээг илүү үр дүн, ач холбогдолтой болгосон гэж оролцогчид үзжээ. Бага хурлын үр дүнгээс харахад нэр хүнд бүхий олон улсын санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид болон Олон улсын Костодиан банкууд манай орны хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах мөн хамтран ажиллах хүсэл эрмэлзэл өндөр байна.

Монголын хөрөнгийн биржээс зохион байгуулдаг “Үнэт цаасны зах зээлийн анхан шатны мэдлэг олгох сургалт” 2013 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр эхэлнэ. Бүртгэл явагдаж байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг www.mse.mn хаягаар эсвэл 11-313747 утсаар холбогдож авна уу.